



Safety & Security

Монгол улсын хууль болон иргэний нисэхийн баримт бичигт

Улаанбаатар хот



Иргэний нисэхийн нэр, томъёо

Иргэний нисэхийн тухай хууль болон ИНД-ийг иргэний нисэхийн дүрмийн тайлбараар ойлгоно гэсэн ICAO-ийн түгээмэл шаардлага байдаг.

Монгол улсын ИНД-1 нь 2007 онд анх батлагдсан бөгөөд 2010 онд шинэчлэн батлагдсан боловч ойлгомжгүй шалтгаанаар ХЗДХЯамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байна.

“Иргэний нисэхэд хэрэглэгдэх бусад нэр томъёог иргэний нисэхийн нэр томъёоны дүрэм болон холбогдох иргэний нисэхийн дүрэмд зааснаар ойлгоно” гэсэн заалтыг Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бид тусгаж байгаа.

Иргэний нисэхийн нэр, томъёог ICAO, FAA, EASA зэрэг олон байгууллагууд өөрийн зорилгоор тайлбарласан байдаг бөгөөд энэ нь заримдаа Монгол улсын ИНД болон түүний эх үүсвэр болгон ашиглаж байгаа Шинэ-Зеландын үг хэллэг, утга агуулгатай зөрчилддөг.

Чикагогийн конвенцийн Хавсралтуудад хүртэл өөрийн зохицуулалтын агуулгаас шалтгаалан нэг үгийг өөр, өөр утгаар тайлбарласан байдаг жишээтэй.

Иймд Иргэний нисэхийн тухай хууль болон ИНД-ийг нэгдсэн нэг ойлголтоор ойлгож, унших зорилгоор ИНЕГ-аас дүрмийн шинэчлэлийн хүрээнд ИНД-1-ийг сэргээн боловсруулж, батлуулах ажил хийгдэж байна.

Энэ ажлын хүрээнд иргэний нисэхийн түлхүүр ойлголт болох safety, security зэрэг үгүүдийг зөв ойлгож, хэрэглэх нь нэн тэргүүнд шаардлагатай байна.



Safety & Security in different languages

French

- ❖ The French word « Sécurité » is used to translate both « Safety » and « Security ». In some industries, the word « Sûreté » is used to translate « Safety ».

German

- ❖ The German word « Sicherheit » is used to translate both « Safety » and « Security ». For this reason the English terms are usually preferred.

Russian

- ❖ The Russian word «безопасность» is used to translate both « Safety » and « Security ». « безопасность полётов », « безопасность, защита »

зэрэг 5 хэл дээр нэг үгээр илэрхийлэгддэг ойлголт юм.



Definition / Тодорхойлолт

The new Oxford dictionary of English describes the words in the following way:

Safety:

- 1) The condition of being protected from or unlikely to cause danger, risk or injury.
 - ❖ Denoting something designed to prevent injury or damage, e.g. safety barrier

Safe:

- 1) Protected from or not exposed to danger or risk; not likely to be harmed or lost
 - ❖ Not likely to cause or lead to harm or injury; not involving danger or risk
 - ❖ (of a place) Affording security or protection
- 2) Uninjured; with no harm done

From the Latin word 'saluses' – uninjured

Security:

- 1) the state of being free from danger or threat, e.g. “the system is designed to provide maximum security against toxic spills”
 - ❖ the safety of a state or organizations against criminal activities such as terrorism, theft or espionage
 - ❖ procedures followed or measures taken to ensure such safety
 - ❖ the state of feeling safe, stable and free from fear or anxiety

From the Latin word 'securus'; 'se'-without, 'cara' – care, - 'securus' – free from care

Secure:

- ❖ not subject to threat; certain to remain or continue safe and unharmed
- ❖ protected against attack or other criminal activity
- ❖ feeling safe, stable and free from fear and anxiety



Definition / Тодорхойлолт

ICAO Doc 9713

Safety - безопасность полётов

Security - безопасность

Safeguarding civil aviation against acts of unlawful interference. This objective is achieved by a combination of measures and human and material resources.

Защита гражданской авиации от актов незаконного вмешательства. Эта цель достигается путем реализации комплекса мер и привлечения людских и материальных ресурсов.

(<https://www.ntnu.edu/>)

Safety is protection against random incidents. Random incidents are unwanted incidents that happen as a result of one or more coincidences.

Security is protection against intended incidents. Wanted incidents happen due to a result of deliberate and planned act.

(www.saflex.com)

Safety = refers to freedom from the risk OR occurrence of injury/loss from natural cause

Security = refers to freedom from the risk OR occurrence of injury/loss from the intentional actions of mankind



Safety, security - Үгийн үндэс

Be safe – Аюулгүй байх

Unsafe – Аюултай

Safety – Аюулгүй байдал



Be secure – Хамгаалагдсан байх

Unsecure – Хамгаалалтгүй

Security – Аюулгүйн хамгаалалт



Safety it's a choice not a chance - Аюулгүй байдал бол боломж биш, сонголт

Make safety your first priority - Аюулгүй байдлыг та үндсэн зорилгоо болго

Safety first - Аюулгүй байдал нэгдүгээрт

Safety always - Аюулгүй байдлыг байнга сахь

The Best way is the safe way - Зөв зам бол аюулгүй зам

Think safe, Work safe, Be safe - Аюулгүй байхаар бодож, аюулгүй ажилласнаар, та аюулгүй байна



Safety & Security Монгол улсын хуулиудад

Монгол Улсын үндсэн хууль:

11.1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн. - (*Энэ ойлголтод safety & security аль аль нь багтсан байна*)

Үндэсний аюулгүй байдлын тухай хууль:

3 дугаар зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай ойлголт

3.1. "Үндэсний аюулгүй байдал" гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. - (*safety & security*)

3.4. Үндэсний аюулгүй байдал нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

3.4.1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.2. нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.3. иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.4. эдийн засгийн аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.5. шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.6. мэдээллийн аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.7. монгол соёл иргэншлийн аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.8. хүн ам, удмын сангийн аюулгүй байдал - (*safety*)

3.4.9. экологийн аюулгүй байдал - (*safety & security*)

3.4.10. хүнсний аюулгүй байдал - (*safety & security*)



Safety & Security Монгол улсын хуулиудад

Авто замын тухай

10.1.9. олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто замын ашиглалт, засвар, арчлалтын ажлыг нэгдсэн бодлого, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын хэвийн нөхцөлийг хангуулах; - (*safety*)

Авто тээврийн тухай хууль

6.1.5. автотээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх ачаа, зорчигчдын хэмжээ болон тээвэрлэлтийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарын шаардлагын талаар холбогдох улстай тохиролцох; - (*safety & security*)

Усан замын тээврийн тухай

6.1.6. усан замын тээврийн асуудлаар олон улсын үйл ажиллагаанд оролцох, улс хооронд тээвэрлэх зорчигч, ачааны хэмжээ болон тээвэрлэлтийн аюулгүй байдал, үйлчилгээний чанарын шаардлагын талаар холбогдох улстай тохиролцох; - (*safety & security*)

Төмөр замын тээврийн тухай:

1.1. Энэ хуулийн зорилт нь төмөр замын тээврийн үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. - (*safety*)

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай:

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахад оршино. - (*safety*)

Хөдөлмөрийн тухай хууль:

4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй болон хөдөлмөрийн нөхцөлтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна. - (*safety*)



Safety & Security Монгол улсын хуулиудад

Галт зэвсгийн тухай:

11.5. Хот, суурин газарт аюулгүй байдал хангасан буудлага үйлдэх байгууламж /тир/-д спорт-сургалтын буудлага хийж болно. (*safety*)

Донорын тухай:

3.1.9. “цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа” гэж донорын үйлсийг сурталчлах, алдаршуулах, урамшуулах, цусны донор элсүүлэх, цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, хэрэглэх, экспортлох, импортлох ажиллагааг; (*safety*)

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай:

1.1. Энэ хуулийн зорилт нь хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

4.1.4. “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж хүнсийг зориулалтын дагуу бэлтгэж хэрэглэхэд хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулахгүй, сөргөөр нөлөөлөхгүй байхыг; (*safety*)

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль:

5.4. Бараа, ажил, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаагүйгээс хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсны төлбөрийг Иргэний хуулийн арван найм, тавин хоёрдугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй. (*safety*)

Цөмийн энергийн тухай:

3.1.3. “цөмийн болон цацрагийн аюулгүй байдал” гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цөмийн төхөөрөмж, цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг хангасныг; (*safety*)



Safety & Security Монгол улсын хуулиудад

Эрүүл ахуйн тухай:

7.4. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ чанар, аюулгүй байдлыг хангаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүсэх сөрөг үр дагавар, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах арга хэмжээг бүрэн хариуцна. (*safety*)

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай

1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, төрийн байгууллагын удирдлага, хяналтын тогтолцоо, ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах, ажилтан, хөдөлмөр эрхлэгч иргэнийг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.1.18. "үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал" гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг; (*safety*)

"Safety", "security" ойлголтыг өнөөгийн Иргэний нисэхийн тухай хуульд дараах байдлаар учир дутагдалтай, ташаа тайлбарласан байдаг:

Иргэний нисэхийн тухай

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

3.1.13. "нисэхийн аюулгүй ажиллагаа" гэж нислэгийн үйл ажиллагаа болон түүнд хамаарах бусад үйл ажиллагааг хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөд хохирол учруулахгүйгээр гүйцэтгэх нөхцөл байдал болон чадварыг; (*safety*)

3.1.17. "нисэхийн аюулгүй байдал" гэж нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон цогцолбор арга хэмжээ; (*security*)



Safety & Security хууль, дүрэмд

Монгол хэлний их тайлбар толь (<https://www.mongoltoli.mn/>)

- ❖ Аюулгүй байдлыг хангах - осол аюулгүй байхаар бүх зүйлийг зохицуулах; (**safety**)
- ❖ Аюулгүй ажиллагааны зааварчилгаа - хөдөлмөрийн үед хэрхэн аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай заасан дүрэм журам; (**safety**)

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай

3.1.18. "үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдал" гэж зураг төсөл, техникийн баримт бичигт заасан нөхцөлийн дагуу тоног төхөөрөмжийг ажиллуулахад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байхыг;

Цөмийн энергийн тухай:

3.1.3. "цөмийн болон цацрагийн аюулгүй байдал" гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цөмийн төхөөрөмж, цацрагийн үүсгүүрийн аюулгүй ажиллагааг хангасныг;

Жишээ: Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг дүрэм

35. Даралтат сав, уурын болон усан халаалтын зуух, ачаа өргөх кран, цахилгаан болон дулааны тоног төхөөрөмжүүдийг байрлуулах, тоноглох, ашиглах үед "Даралтат савыг төхөөрөмжлөх аюулгүй ажиллагааны дүрэм", "Уур усан халаалтын зуухыг төхөөрөмжлөх аюулгүй ажиллагааны дүрэм", "Ачаа өргөх, краныг төхөөрөмжлөх аюулгүй ажиллагааны дүрэм", "Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм"-ийн шаардлагыг баримтална.



Safety (47 ИНД-д 809 удаа)

Англи	Одоогийн ойлголтоор: Safety - аюулгүй ажиллагаа
safety board	аюулгүй ажиллагааны зөвлөл
work safety	хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа
passenger safety	зорчигчийн аюулгүй ажиллагаа
safety of an aircraft operation	агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй ажиллагаа
aviation safety	нисэхийн аюулгүй ажиллагаа
flight safety	нислэгийн аюулгүй ажиллагаа
product safety	бүтээгдэхүүний аюулгүй ажиллагаа
safety directives	аюулгүй ажиллагааны удирдамж
safety inspection	аюулгүй ажиллагааны үзлэг
safety practices	аюулгүй ажиллагааны дадлага туршлага
safety measures	аюулгүй ажиллагааны арга хэмжээ
safety precautions	аюулгүй ажиллагааны урьдчилсан анхааруулга
safety pilot	аюулгүй ажиллагааны нисгэгч
interests of safety	аюулгүй ажиллагааны ашиг сонирхол
transport safety act	замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны тухай хууль
safety area	аюулгүй ажиллагааны талбай
public safety	нийтийн аюулгүй ажиллагаа
safety belt	аюулгүй ажиллагааны бүс
safety training	аюулгүй ажиллагааны сургалт
safety management	аюулгүй ажиллагааны удирдлага
safety policy	аюулгүй ажиллагааны бодлого
safety equipment	аюулгүй ажиллагааны төхөөрөмж
safety harness for each seat	суудал бүрийн аюулгүй ажиллагааны бэхэлгээ
endanger safety of any person	аливаа этгээдийн аюулгүй ажиллагаанд аюул учруулах
safety audit	аюулгүй ажиллагааны аудит
safety of persons and property	хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй ажиллагаа
equivalent level of safety	аюулгүй ажиллагааны дүйцэх түвшин



Security (19 ИНД-д 595 удаа орсон)

Англи	Одоогийн ойлголтоор:Security - аюулгүй байдал
cargo security incident	ачааны аюулгүй байдлын зөрчил
security incident	аюулгүй байдлын зөрчил
security control	аюулгүй байдлын хяналт
security area	аюулгүй байдлын бүс
security enhanced area	өндөржүүлсэн аюулгүй байдлын бүс
security checks	аюулгүй байдлын шалгалт
national security	үндэсний аюулгүй байдал
security screening	аюулгүй байдлын үзлэг
air operator security program	агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр
security procedures	аюулгүй байдлын журам
aviation security	нисэхийн аюулгүй байдал
declaration of security	аюулгүй байдлын мэдүүлэг
security requirements	аюулгүй байдлын шаардлага
aviation security service organisations	нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллага
security designated aerodrome	аюулгүй байдал тогтоогдсон аэродром
security designated navigation installations	аюулгүй байдал тогтоогдсон навигацийн байгууламж
non-security designated aerodromes	аюулгүй байдал тогтоогоогүй аэродром
security escorts	аюулгүй байдлын дагалдах ажиллагаа
security officer	аюулгүй байдлын ажилтан
security service	аюулгүй байдлын үйлчилгээ
security technique	аюулгүй байдлын арга техник
aerodrome security	аэродромын аюулгүй байдал
random security spot check	аюулгүй байдлын гэнэт сонгох үзлэг
screening point security	үзлэгийн цэгийн аюулгүй байдал



Analysis / Дүн шинжилгээ

Үндсэн хуульд хэрэглэж байгаа “Аюулгүй байдал” гэсэн ойлголт нь “safety” болон “security” аль алиныг багтаасан цогц ойлголт юм.

Гэтэл нисэхийн салбарт аюулгүй байдлыг “security” гэж ойлгодог нь бодит нөхцөл байдал болон Үндсэн хуулийн агуулгатай зөрчилдөж байна.

“Safety”-г “аюулгүй ажиллагаа” гэж томъёолсон нь нислэгийн аюулгүй байдлын цогц, түгээмэл ойлголтыг бүрхэгдүүлж, нислэгийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Understanding the Difference of Safety vs. Security, May Soon Save Lives.

Safety болон Security-ийн ялгааг зөв ойлгох нь олон хүний амь насыг цаг алдалгүй аврах боломжийг бүрдүүлнэ.




SAFETY

- GOALS:
- Prevent accidents and incidents
 - Improve work conditions
 - Reduce impact on health

SECURITY

- GOALS:
- Prevent misuse
 - Prevent terrorism
 - Protect equipment





- ❖ Safety – Аюулгүй байдал;
- ❖ Security – Аюулгүйн хамгаалалт гэж томъёолвол Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуультай зөрчилдөхгүй, утга санаа бүрхэгдэхгүй бөгөөд иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий үйл ажиллагаа улам ойлгомжтой, тодорхой, үр дүнтэй болно.

"Safety" and "Security" are too often used interchangeably; as if they mean the same thing. This can be a losing proposition.

"Safety" болон "Security"-г ижил утгаар ойлгож хэрэглэдэг.

Энэ бол маш аюултай төөрөгдөл юм.



Safety (47 ИНД-д 809 удаа)

Англи	Safety - аюулгүй байдал
safety board	аюулгүй байдлын зөвлөл
work safety	хөдөлмөрийн аюулгүй байдал
passenger safety	зорчигчийн аюулгүй байдал
safety of an aircraft operation	агаарын хөлгийн үйл ажиллагааны аюулгүй байдал
aviation safety	нисэхийн аюулгүй байдал
flight safety	нислэгийн аюулгүй байдал
product safety	бүтээгдэхүүний аюулгүй байдал
safety directives	аюулгүй байдлын удирдамж
safety inspection	аюулгүй байдлын үзлэг
safety practices	аюулгүй байдлын дадлага туршлага
safety measures	аюулгүй байдлын арга хэмжээ
safety precautions	аюулгүй байдлын урьдчилсан анхааруулга
safety pilot	аюулгүй байдлын нисгэгч
interests of safety	аюулгүй байдлын ашиг сонирхол
transport safety act	замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
safety area	аюулгүй байдлын талбай
public safety	нийтийн аюулгүй байдал
safety belt	аюулгүй байдлын бүс
safety training	аюулгүй байдлын сургалт
safety management	аюулгүй байдлын удирдлага
safety policy	аюулгүй байдлын бодлого
safety equipment	аюулгүй байдлын төхөөрөмж
safety harness for each seat	суудал бүрийн аюулгүй байдлын бэхэлгээ
endanger safety of any person	аливаа этгээдийн аюулгүй байдалд аюул учруулах
safety audit	аюулгүй байдлын аудит
safety of persons and property	хүмүүс болон эд хөрөнгийн аюулгүй байдал
equivalent level of safety	аюулгүй байдлын дүйцэх түвшин



Security (19 ИНД-д 595 удаа орсон)

Англи	Security - аюулгүйн хамгаалалт
cargo security incident	ачааны аюулгүйн хамгаалалтын зөрчил
security incident	аюулгүйн хамгаалалтын зөрчил
security control	аюулгүйн хамгаалалтын хяналт
security area	аюулгүйн хамгаалалттай бүс
security enhanced area	өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс
security checks	аюулгүйн хамгаалалтын шалгалт
national security	үндэсний аюулгүйн хамгаалалт
security screening	аюулгүйн хамгаалалтын үзлэг
air operator security program	агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр
security procedures	аюулгүйн хамгаалалтын журам
aviation security	нисэхийн аюулгүйн хамгаалалт
declaration of security	аюулгүйн хамгаалалтын мэдүүлэг
security requirements	аюулгүйн хамгаалалтын шаардлага
aviation security service organisations	нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага
security designated aerodrome	аюулгүйн хамгаалалттай аэродром
security designated navigation installations	аюулгүйн хамгаалалттай навигацийн байгууламж
non-security designated aerodromes	аюулгүйн хамгаалалтгүй аэродром
security escorts	аюулгүйн хамгаалалт дагалдах ажиллагаа
security officer	аюулгүйн хамгаалалтын ажилтан
security service	аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ
security technique	аюулгүйн хамгаалалтын арга техник
aerodrome security	аэродромын аюулгүйн хамгаалалт
random security spot check	аюулгүйн хамгаалалтын гэнэт сонгох үзлэг
screening point security	үзлэгийн цэгийн аюулгүйн хамгаалалт



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА